



## БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баяннуур сумын ЭМТ-ийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: БУА-2023/118/-НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Булган аймаг

2023 он

Аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ

Утас: 70342580 Цахим хаяг: Erdene.B@audit.local

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 70342716 Цахим хаяг:

Enkhtsoodolj@audit.gov.mn

Аудитор З.Ганбаатар

Утас: 70342716 Цахим хаяг: ganbaatarz@audit.gov.mn

Аудитор:

Утас: 70342716 Цахим хаяг:

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....
  2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
  3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
    - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....
    - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....
    - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....
    - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....
  4. Аудитын тайлан .....
  - 4.1 Ерөнхий зүйл .....
  - 4.2 Материаллаг байдал .....
  - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
  - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
  - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
  - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....
5. Аудитын илрүүлэлт .....
  - .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....

## **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

---

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан



**БУЛГАН АЙМГИЙН  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс: 7034-2580  
E-mail: bulgan@audit.gov.mn

2023.02.24 № 142

танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ Т

**БАЯННУУР СУМЫН ЭМТ-ИЙН ДАРГА  
Б.ҮҮРИЙНТУЯА ТАНАА**

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд Ковид 19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг төлөвлөн, оношлох, тандах, эмчлэх, хянах, тархвар судлалын асуумж авах, дархлаажуулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэн 362 тохиолдлыг эмчилсэн байна.

Тандалт судалгаанд давхардсан тоогоор 3,759.0 иргэнийг хамруулж, голомтод 9,858.0 м2 талбайг ариутгаж, урьдчилсан сэргийлэх халдваргүйтгэлийг 22 байгууллагын 14,720.0 м2 талбайд тус тус хийсэн байна.

006020178

### **Аудитын гол асуудал**

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны үйл ажиллагааны зардлыг Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих 540,605.7, орон нутгийн төсвөөс 30,187.8, бусад орлого 2,225.5 нийт 573,019.1 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлж 509,316.9 мянган төгрөгийг зарцуулан орон нутгийн төсөвт 911.1 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Тайлант онд үнэ төлбөргүй 33,085.0, төсвийн хөрөнгөөр 11,355.3 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус худалдан авч тайлант онд нийт 44,440.3 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө нэмэгдсэн байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.ЭРДЭНЭ

## САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>150,078,074.62</u></b>	<b><u>149,035,367.79</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b><u>6,015,230.03</u></b>	<b><u>58,362,067.03</u></b>
31211	Төрийн сангийн харилцах	6,015,230.03	58,362,067.03
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b><u>70,016,898.68</u></b>	
<b>3351</b>	Байгууллагаас авах авлага	70,016,898.68	
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	74,045,945.91	70,673,300.76
<b>354</b>	Түүхий эд материал		
<b>3542</b>			
<b>351</b>	Тусгай зориулалтын материал		
3511	Эм боох материал	67,886,303.71	87,623,324.76
3513	Хангамжийн материал	6,159,642.20	3,049,976.00
35410			
35420	Аж ахуйн материал	1,824,250.00	1,447,270.00
35440	Хүнсний материал	3,715,847.30	1,367,586.00
35450	Түлш шатах материал	384,424.90	
35470	Бусад хангамжийн материал	235,130.00	235,120.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>429,165,787.18</u></b>	<b><u>390,108,028.28</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b><u>429,165,787.18</u></b>	<b><u>390,108,028.28</u></b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	420,289,787.14	381,232,028.28
39201	Барилга, байгууламж, орон сууц	242,109,629.67	241,286,429.67
39202	Хуримтлагдсан элэгдэл	-38,672,682.96	-47,424,257.92
39203	Авто-тээврийн хэрэгсэл	126,872,000.00	70,672,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-40,464,499.86	-19,295,333.35
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	170,711,789.98	189,795,321.98
39206	Хуримтлагдсан элэгдэл	-54,051,023.80	-70,297,185.89
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	17,539,166.40	22,209,166.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	-7,690,592.29	-10,433,905.89
39215	Бусад үндсэн хөрөнгө	3,936,000.00	5,216,400.00
39216	Хуримтлагдсан элэгдэл		-496,606.72
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	8,876,000.04	8,876,000.04
39301	Програм хангамж	100,000.00	100,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-99,999.96	-100,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	8,876,000.00	8,876,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>579,243,861.80</u></b>	<b><u>539,143,396.07</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>2,878,758.00</u></b>	<b><u>1,502,275.77</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>2,878,758.00</u></b>	<b><u>1,502,275.77</u></b>
<b>413</b>	Өглөг	<b><u>2,878,758.00</u></b>	<b><u>1,502,275.77</u></b>
<b>4131</b>	Ажилчидтай холбогдсон өглөг	<b><u>2,878,758.00</u></b>	<b><u>1,502,275.77</u></b>

4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг		0
41361	Байгууллагад төлөх өглөг		
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>576,365,103.80</b>	<b>537,641,120.30</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>576,365,103.80</b>	<b>537,641,120.30</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	216,241,520.90	216,241,520.90
51101	Өмч: - төрийн		
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	161,965,940.97	123,241,957.47
51210	Өмнөх үеийн үр дүн	161,965,940.97	161,965,940.97
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-38,723,983.50
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	198,157,641.93	198,157,641.93
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>579,243,861.80</b>	<b>539,143,396.07</b>

СТ-2А

### САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>944,806,623.38</b>	<b>601,618,866.37</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>225,384,715.38</b>	<b>97,796,346.37</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>225,384,715.38</b>	<b>78,758,023.00</b>
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого -үндсэн хөрөнгө	87,164,717.53	33,085,028.00
120004	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого -бараа материал	138,219,997.85	64,503,618.37
122001	Хандив тусламж	00.00	00.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>719,421,908.00</b>	<b>503,822,520.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	313,166,900.00	00.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	313,166,900.00	00.00
131001	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	00	00.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	102,269,030.00	1,708,990.00
134002	Эрүүл мэндийн даатгалын санхүүжих	269,114,578.00	471,925,730.00
132001	Үйл ажиллагааны санхүүжилт /орон нутаг/	34,871,400.00	30,187,800.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>698,527,644.73</b>	<b>615,833,854.70</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>698,527,644.73</b>	<b>615,833,854.70</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>672,677,644.73</b>	<b>679,342,606.70</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	268,714,976.29	272,682,175.77

210101	Үндсэн цалин	136,029,940.32	156,288,030.87
210102	Нэмэгдэл	70,601,239.97	90,360,307.70
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,382,000.00	3,893,000.00
210104	Урамшуулал	58,701,796.00	22,140,837.20
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>37,198,166.00</b>	<b>35,374,100.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	27,842,366.00	24,526,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,477,300.00	2,711,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,839,600.00	2,169,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	459,900.00	581,930.15
210205	Эрүүл мэндийн даатгал	4,579,000.0	5,384,169.85
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>36,360,409.00</b>	<b>30,942,090.90</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,709,201.00	3,116,230.00
210302	Түлш, халаалт	32,003,208.00	27,552,860.90
210303	Цэвэр, бохир ус	648,000.00	273,000.00
210304	Байрны түрээс	00.00	
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>22,738,881.00</b>	<b>43,340,325.00</b>
210401	Бичиг хэрэг	4,656,550.00	1,700,500.00
210402	Тээвэр, шатахуун	14,795,070.00	20,390,935.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,193,900.00	2,222,800.00
210404	Ном, хэвлэл	00.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	10,768,900.00	9,988,230.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,887,643.00	9,037,860.00
210407	Бараа материал акталсаны зардал	52,000.00	00.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>218,895,337.93</b>	<b>109,249,430.71</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,380,000.00	6,911,600.00
210501	Эм бэлдмэл эмнэлэгийн хэрэгсэл	197,966,653.23	96,321,669.41
210502	Хоол хүнс	13,548,684.70	6,016,161.30
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>6,372,000.00</b>	<b>9,690,900.00</b>
210604	Урсгал засвар	1,548,000.00	9,162,900.00
210601	Багаж техник	4,824,000.00	528,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,050,000.00</b>	<b>1,120,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,050,000.00	1,120,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>7,885,629.00</b>	<b>4,200,439.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,885,629.00	3,726,249.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	00.00	474,190.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>57,847,063.51</b>	<b>72,743,145.32</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,131,432.00	13,754,053.59
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,090,000.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	35,625,631.51	58,989,091.73
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>25,850,000.00</b>	<b>36,491,248.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>25,850,000.00</b>	<b>35,580,122.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	00.00

213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	25,850,000.00	35,580,122.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		911,126.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		911,126.00
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00,00	
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>00.00</b>	
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>246,278,978.65</u></b>	<b><u>-14,214,988.33</u></b>
225	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b><u>6,487,950.00</u></b>	<b><u>24,508,995.17</u></b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	<u>6,487,950.00</u>	<u>24,508,995.17</u>
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮД ДҮН</b>	<b><u>-6,487,950.00</u></b>	<b><u>-24,508,995.17</u></b>
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>239,791,028.65</u></b>	<b><u>-38,723,983.50</u></b>

СТ-2А

### МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>650,776,908.00</u></b>	<b><u>573,019,070.00</u></b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	00.00	516,550.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b><u>650,776,908.00</u></b>	<b><u>572,502,520.00</u></b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	313,166,900.00	00.00
131001	<b>Урсгал үйл ажиллагааны санхүүжилт</b>		00.00
131001	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжилт	00.00	00.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	33,624,030.00	1,708,990.00
134002	<b>Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих</b>	269,114,578.00	540,605,730.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	34,871,400.00	30,187,800.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	00.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>575,101,777.97</u></b>	<b><u>509,316,933.00</u></b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b><u>575,101,777.97</u></b>	<b><u>509,316,933.00</u></b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b><u>549,551,777.97</u></b>	<b><u>472,825,685.00</u></b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	268,980,198.97	271,179,900.00
210101	Үндсэн цалин	136,295,163.00	154,785,755.10
210102	Нэмэгдэл	70,601,239.97	90,360,307.70
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,382,000.00	3,893,000.00
210104	Урамшуулал	58,701,796.00	22,140,837.20

<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	37,198,166.00	120,684,550.04
210201	Тэтгэврийн даатгал	28,000,166.00	24,526,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,299,500.00	2,711,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,839,600.00	2,169,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	459,900.00	581,930.15
210205	Эрүүл мэндийн даатгал	4,599,000.00	5,384,169.85
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	33,595,201.00	286,606,600.00
210301	Гэрэл, цахилгаан	3,509,201.00	2,400,000.00
210302	Түлш, халаалт	29,586,000.00	30,701,874.00
210303	Цэвэр, бохир ус	500,000.00	273,000.00
210304	Байрны түрээс	00.00	00.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	35,802,170.00	40,187,235.00
210401	Бичиг хэрэг	4,050,800.00	1,700,500.00
210402	Тээвэр, шатахуун	14,795,070.00	20,390,935
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,779,800.00	2,222,800.00
210404	Ном, хэвлэл	00.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	10,650,500.00	7,236,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,526,000.00	8,636,200.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	141,013,407.00	67,710,037.00
<b>210501</b>	<b>Эм бэлдмэл</b>	120,687,117.00	57,213,037.00
<b>210502</b>	<b>Хоол хүнс</b>	16,237,290.00	3,585,400.00
<b>210503</b>	<b>Нормын хувцас, зөөлөн эдлэл</b>	4,089,000.00	6,911,600.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засвар</b>	7,157,400.00	11,841,300.00
210601	Багаж техник, хэрэгсэл	4,102,000.00	528,000.00
210604	Урсгал засвар	3,055,400.00	11,313,300.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,050,000.00	1,120,000.00
210702	Дотоод албан томилолт	1,050,000.00	1,120,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	9,098,455.00	4,516,039.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,101,555.00	3,620,500.00
210802	Аудит баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	55,000.00	57,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	108,900.00	264,717.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	1,350,000.00	474,190.00
210807	Газрын төлбөр		66,032.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	15,656,780.00	7,522,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,167,780.00	7,522,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	489,000.00	00.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>25,550,000.00</b>	<b>36,491,248.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	25,550,000.00	35,580,122.00
213204	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	18,000,000.00	35,580,122.00

213209	Нэг удаагийн тэтгэмж ,шагнал,урамшуулал	7,550,000.00	
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		911,126.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		
2134	ОН-ийн төсвийн ерөнхийлөн захирагчид олгох татаас санхүүжилт	00,00	
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00,00	911,126.00
<b>3213403</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>75,675,130.03</u></b>	<b><u>63,702,137.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b><u>73,761,900.00</u></b>	<b><u>11,355,300.00</u></b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b><u>73,761,900.00</u></b>	<b><u>11,355,300.00</u></b>
	<b>Дотоод эх үүсвэрээр</b>		
<b>222001</b>	<b>Тоног төхөөрөж</b>	<b><u>73,761,900.00</u></b>	<b><u>11,355,300.00</u></b>
<b>223001</b>	<b>Бусад хөрөнгө</b>	0	
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	<u>73,761,900.00</u>	<u>11,355,300.00</u>
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<u>-73,761,900.00</u>	<u>-11,355,300.00</u>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>0.00</u></b>	<b><u>52,346,837.00</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	1,913,230.03	<b><u>52,346,837.00</u></b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>6,015,230.03</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b><u>58,362,067.03</u></b>

СТ-4А

## ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	216,241,520.90	198,157,641.93	161,965,940.97	00.00	576,365,103.80
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-38,723,983.50	00.00	-38,723,983.50
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	216,241,520.90	198,157,641.93	123,241,957.47	00.00	537,641,120.30

## ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	531,561,800.00	520,672,233.00
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	531,561,800.00	509,316,933.00
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	495,561,800.00	472,825,685.04
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	271,179,900.00	271,179,900.00
210101	Үндсэн цалин	161,047,000.00	154,785,755.10
210102	Нэмэгдэл	86,213,300.00	90,360,307.70
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,830,500.00	3,893,000.00
210104	Урамшуулал	20,089,100.00	22,140,837.20
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	35,339,100.00	35,374,100.00
210201	Тэтгэврийн даатгал	24,491,800.00	24,526,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,711,800.00	2,711,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,169,400.00	2,169,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	542,400.00	542,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,423,700.00	5,423,700.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	34,286,000.00	33,374,874.00
210301	Гэрэл, цахилгаан	2,400,000.00	2,400,000.00
210302	Түлш, халаалт	31,586,000.00	30,701,874.00
210303	Цэвэр, бохир ус	300,000.00	273,000.00
210304	Байрны түрээс		
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	42,950,500.00	40,187,235.00
210401	Бичиг хэрэг	1,830,400.00	1,700,500.00
210402	Тээвэр шатахуун	22,254,900.00	20,390,935.00
210403	Шуудан холбоо	2,327,800.00	2,222,800.00
210405	Хог хаягдал зайлуулах	7,675,700.00	7,236,800.00
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх	8,861,700.00	8,636,200.00
2105	<b>Нормативт зардал</b>	72,676,600.00	67,710,037.00
210501	Эм бэлдмэл	58,807,400.00	57,213,037.00
210502	Хоол хүнс	6,939,600.00	3,585,400.00
210503	Нормын хувцас	6,929,600.00	6,911,600.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	24,517,000.00	11,841,300.00
210601	Багаж техник хэрэгсэл	11,500,000.00	528,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	300,000.00	00.00
210604	Урсгал засвар	12,717,000.00	11,313,300.00
2107	<b>томилолт</b>	1,500,000.00	1,120,000.00

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	5,395,500.00	4,516,039.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,653,600.00	2,653,600.00
210807	Газрын төлбөр	66,100.00	66,032.00
210803	Даатгалын үйляилгээ	57,600.00	57,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	272,000.00	264,717.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	34,800.00	33,000.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	965,000.00	474,190.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	7,717,200.00	7,522,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,717,200.00	7,522,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	00.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	36,000,000.00	35,580,122.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	36,000,000.00	35,580,122.00
213209	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	36,000,000.00	35,580,122.00
2134	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		911,126.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		911,126.00
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>		11,355,300.00
222001	Тоног төхөөрөмж		11,355,300.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	579,034,290.00	573,019,070.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	00.00	00.00
<b>131104</b>	<b>Нэмэлт санхүүжих</b>	1,708,990	1,708,990.00
134002	Эрүүл мэндийн даатгалын санхүүжих	540,605,730.00	540,605,730.00
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	34,286,000.00	34,286,000.00
132001	Орон нутгийн төсвөөс	34,286,000.00	34,286,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	516,550.00	516,550.00
31	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		58,362,067.03
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	18.00	18.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	12.00	12.00
620003	Үйлчлэх ажилтан	5.00	5.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>18.00</b>	<b>18.00</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	00.00	00.00
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	00.00	00.00
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	00.00	00.00
650004	ССБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	00.00	00.00
650005	ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ)	00.00	00.00
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	00.00	00.00
650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)	00.00	00.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	13.00	13.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	05.00	05.00
650010	Гэрээт ажилтан	00.00	00.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	00.00	00.00

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

---

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Ковид 19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ төлөвлөн, оношлох, тандах, эмчлэх, хянах, тархвар судлалын асуумж авах, дархлаажуулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэн 362 тохиолдлыг эмчлэн, "Коронавирусын эсрэг" дархлаажуулалтад 1-р 89,8%, 2-р 97%, 3-р 86.5% иргэдийг тус тус хамруулсан. Тандалт судалгаанд давхардсан тоогоор 3759 иргэнийг хамруулж, өдөр бүр хяналт тавин ажилсан. Голомтын халдваргүйтгэл 9858м2, урьдчилсан сэргийлэх халдваргүйтгэлийг 22 байгууллагын 14720 м2 талбайд тус тус хийсэн байна. "Эрүүл мэнд" дэд хөтөлбөр, үндэсний 14 төрлийн хөтөлбөрүүдийг үндсэн чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэн, үр дүнг тооцон, төлөвлөлт хийн 13 ажлыг биелүүлж биелэлт 92.8 хувиар дүгнүүлжээ.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Эрүүл мэндийн даатгалын 9, 11, 14 дүгээр зүйлийн дагуу ЭМДҮЗ-ийн 1-6 дугаар тогтоол, бусад эрүүл мэндийн сайдын шинэчлэлтэй холбогдон гарсан хууль эрх зүйн актуудын мөрдлөг болгон ажилласан.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй, НБББББ-ийг 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/179 дугаар тушаалаар шинэчлэн баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй /үр нөлөөгүй байна.

Дотоод хяналттай холбоотойгоор байгууллагын жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг чанартай үр дүнтэй хийсэн эсэхийг шалгахаар горим хэрэгжүүлсэн

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баяннуур сумын ЭМТ-ийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл/мөнгөн* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад *нийцсэн байна*.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баяннуур сумын ЭМТ-ийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 40.1 сая төгрөгөөр буюу 6.9 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	6,015.2	58,362.1	52,346.9
Авлага	70,016.8	0	-70,016.8
Бараа материал	74,045.9	90,673.3	16,627.4
Үндсэн хөрөнгө	429,165.7	390,108.0	-39,057.7
<b>Нийт хөрөнгө</b>	<b>579,243.8</b>	<b>539,143.3</b>	<b>-40,100.5</b>
Өр төлбөр	2,878.7	1,502.2	-1,376.5
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	576,365.1	537,641.2	-38723.9
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>579,243.8</b>	<b>539,143.3</b>	<b>-40,100.5</b>

Дээрх хүснэгтээс харахад бараа материал өмнөх оны үзүүлэлтээс 16,627.4 өсөж, үндсэн хөрөнгө 39,057.7 мянган төгрөгөөр буурчээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд гүйцэтгэлээр зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг эрүүл мэндийн даатгалын сангаас 540,605,730 төгрөгөөр, нэмэлт санхүүжилт 1,708,990 төгрөг, орон нутгийн төсөв 30,187,800 төгрөг төсөвт байгууллагын өөрийн орлого 516,550 төгрөг нийт зарлагыг 573,019,070 төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн төслийн саналын дүнгээр төсөв баталсан.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын сангаас 540,605,730 төгрөгөөр, нэмэлт санхүүжилт 1,708,990 төгрөг, орон нутгийн төсөв 30,187,800 төгрөг төсөвт байгууллагын өөрийн орлого 516,550 төгрөг, өмнөх оны үлдэгдэл 6,015,230.03 нийт 579,034,300.03 төгрөгийн санхүүжилт авч 509,316,933 төгрөгийг зарцуулж үлдэгдэл 58,362,067.03 төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна

#### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан

гаргана.” гэж заасны дагуу Баяннуур сумын ЭМТ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор З.Ганбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Баяннуур сумын ЭМТ-ийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01/08 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүжилтийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүжилтийн дүнгийн 1,379.5 сая төгрөгөөс 75 хувиар буюу 25.7 сая төгрөгөөр тогтоосныг аудитын гүйцэтгэлийн шатанд дахин хянаж шинэчлэн тогтоох *шаардлагагүй* гэж үзлээ.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль *хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь*

Өөрийн байгууллагын тээврийн хэрэгсэлд бүртгэлтэй УАЗ пургон БУА 21-34 улсын дугаартай, УАЗ-31510 БУЛ 15-40 дугаартай автомашиныг төрийн хэмнэлтийн хуулийн дагуу Аймгийн ИТХ-ын 2022 оны XI дугаар хуралдааны XI/09 тогтоолоор дуудлага худалдаагаар худалдан борлуулсан.

#### **Аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга,

нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд 2022 онд нийт 149 мэдээ мэдээлэхээс хуулийн хугацаанд 136 мэдээг бүрэн мэдээлж, хугацаа хоцорсон мэдээ 13 байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

*Завсрын аудит хийгдээгүй болно.*

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Баяннуур сумын ЭМТ-ийн 2022 оны 06 дүгээр сарын 02-ны өдрийн 01/60 тоот албан бичгээр акт, зөвлөмжийн хэрэгжилтийн биелэлтийг хүргүүлсэн байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

*/мянган төгрөгөөр/*

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1		1		100
Албан шаардлага	1	0	1	0	100
Зөвлөмж	1	0	1	0	100
<b>Нийт дүн</b>	<b>3</b>		<b>3</b>		<b>100</b>

*Хэрэгжээгүй төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж байхгүй болно.*

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Үндсэн хөрөнгө болон бараа материалыг хагас болон жилийн эцсийн тооллогоор тооцоо бодсон акт үйлдэж ажилласан эсэх.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 7,065.8 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснээс 7,065.8 мянган төгрөгийн 1 албан шаардлага, алдааг дахин давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

#### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт бичигдээгүй болно.

#### .2 Албан шаардлага

Аудитаар нийт 7.0 сая төгрөгийн зөрчил илэрснээс шилэн дансны тухай хуулийн 3.1-д “заасан этгээд Шилэн дансны тухай хуульд заасан хугацаанд нь байршуулна” гэсэн заалтад нийцээгүйд 7.0 сая төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх албан шаардлага өглөө.

#### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгө, бараа материалын тооллоготой холбоотой асуудал

Илрүүлэлт:

Ерөнхий нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материалын хагас жил болон жилийн эцсийн тооллогод тооцоо бодсон акт үйлдээгүй. Энэ нь Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 345 дугаар тушаалаар баталсан маягт, зааврын дагуу гүйцтээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгө болон бараа материалыг хагас болон жилийн эцсийн тооллогоор тооцоо бодсон акт үйлдэж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## **6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

### **Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Баяннуур сумын ЭМТ	2	7.0	0	0	1	7.0	1	0				
Дүн	1	7.0	0	0	1	7.0	1	0				